

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/285/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ДЭЖИД ЦЭЦЭРЛЭГИЙН 2023
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024-02-25 № 01/155
танай _____-ны № _____-г

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН ДЭЖИД ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Т.БОЛОРМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын Дэжид цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын Дэжид цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 7 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 93,0 хувиар хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	116,876,119.50	138,631,528.07
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	64,317,961.10	83,935,069.67
8	Банкинд байгаа бэлэн мөнгө	64,317,961.10	83,935,069.67
9	Төгрөг	64,317,961.10	83,935,069.67
10	Төрийн сангийн харилцах	64,317,961.10	83,935,069.67
60	БАРАА МАТЕРИАЛ	52,558,158.40	54,696,458.40
66	Хангамжийн материал	52,558,158.40	54,696,458.40
68	Аж ахуйн материал	-	6,000.00
70	Түлш шатах тослох материал	2,168,000.00	132,000.00
72	Хүнсний материал	319,600.00	403,000.00
73	Бусад хангамжийн материал	50,070,558.40	54,155,458.40
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	244,488,236.98	266,004,326.69
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	244,488,236.98	266,004,326.69
108	Биет хөрөнгө	237,536,236.98	259,052,326.69
109	Барилга, байгууламж	206,823,476.87	237,772,531.87
110	Хуримтлагдсан элэгдэл	(25,839,922.56)	(32,299,903.20)
113	Машин, тоног төхөөрөмж	41,073,795.00	48,025,095.00
114	Хуримтлагдсан элэгдэл	(31,463,919.90)	(34,342,415.03)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	52,029,246.50	52,029,246.50
116	Хуримтлагдсан элэгдэл	(29,741,247.64)	(33,316,550.52)
122	Бусад үндсэн хөрөнгө	25,797,300.00	25,797,300.00
123	Хуримтлагдсан элэгдэл	(2,701,196.29)	(6,171,682.93)
125	Номын фонд	1,558,705.00	1,558,705.00
126	Биет бус хөрөнгө	6,952,000.00	6,952,000.00
129	Бусад биет бус хөрөнгө	6,952,000.00	6,952,000.00
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	361,364,356.48	404,635,854.76
138	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	108,000.00	399,017.88
139	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	108,000.00	399,017.88
164	Өглөг	108,000.00	399,017.88
165	Ажиллагчидтай холбогдсон өглөг	-	0.00
166	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	399,017.88
170	Бусад өглөг	108,000.00	-
172	Хувь хүмүст төлөх өглөг	108,000.00	-
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	361,256,356.48	404,236,836.88
215	Засгийн газрын хувь оролцоо	361,256,356.48	404,236,836.88
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	71,758,549.95	71,758,549.95
217	Өмч: -Төрийн өмч	71,758,549.95	71,758,549.95
223	Хуримтлагдсан үр дүн	196,851,106.26	239,831,586.66
224	Өмнөх үеийн үр дүн	196,851,106.26	196,851,106.26
225	Тайлант үеийн үр дүн	-	42,980,480.40
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	92,646,700.27	92,646,700.27
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	361,364,356.48	404,635,854.76

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	719,883,864.86	490,455,155.00
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	699,472,934.86	467,739,455.00
77	Нийтлэг татварын бус орлого	323,240,634.86	32,461,055.00
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	41,331,330.06	-
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	41,331,330.06	-
91	Монгол банкны ашиг	217,166,967.04	31,961,055.00
92	Бусад орлого	64,742,337.76	500,000.00
99	Тусламжийн орлого	376,232,300.00	435,278,400.00
100	Хандив тусламж /дотоод/	376,232,300.00	435,278,400.00
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	20,410,930.00	22,715,700.00
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,410,930.00	22,715,700.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,410,930.00	22,715,700.00
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	340,607,894.74	447,474,674.60
148	УРСГАЛ ЗАРДАЛ	340,607,894.74	447,474,674.60
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	337,476,194.74	435,842,774.60
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	223,396,124.42	291,051,079.73
151	Цалин	176,582,514.36	212,283,468.58
152	Нэмэгдэл цалин	36,509,648.56	68,523,894.55
154	Урамшуулал	10,303,961.50	10,243,716.60
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,394,944.48	36,008,131.70
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	18,120,052.77	24,899,734.97
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,457,931.29	2,997,342.27
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,983,959.74	2,314,273.62
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	434,851.54	524,473.93
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,398,149.14	5,272,306.91
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,907,101.00	24,650,717.88
165	Гэрэл цахилгааны зардал	3,382,898.00	3,919,345.01
166	Түлш, халаалтын зардал	14,634,203.00	19,966,000.00
167	Цэвэр, бохир усны зардал	1,890,000.00	765,372.87
170	Хангамж, бараа материалын зардал	2,119,970.00	4,788,500.00
171	Бичиг хэргийн материал	1,107,050.00	30,000.00
172	Тээвэр, шатахууны зардал	-	3,271,000.00
175	Хог хаягдал устгах, цэвэрлэх	33,000.00	-
176	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	979,920.00	1,487,500.00
181	Нормативт зардал	48,150,250.00	56,262,130.00
182	Эм	-	165,000.00
183	Хоол	47,898,350.00	56,097,130.00
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	251,900.00	-
185	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
189	Урсгал засвар	500,000.00	500,000.00

190	Томилолт, зочны зардал	-	146,000.00
192	Дотоод томилолтын зардал	-	146,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	-	3,579,750.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,932,350.00
200	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	-	647,400.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	16,007,804.84	18,856,465.29
210	Бараа үйлчилгээний бусад зардал	4,682,500.00	-
211	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	-	2,472,200.00
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,325,304.84	16,384,265.29
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,131,700.00	11,631,900.00
228	Бусад урсгал шилжүүлэг	3,131,700.00	11,631,900.00
236	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	3,131,700.00	11,631,900.00
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	379,275,970.12	42,980,480.40
276	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	17,879,363.64	-
281	Үнэ төлбөргүй гарсан зардал	17,879,363.64	-
287	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(17,879,363.64)	-
288	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	361,396,606.48	42,980,480.40

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	396,643,230.00	457,994,100.00
77	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	376,232,300.00	435,278,400.00
100	Тусламжийн орлого	376,232,300.00	435,278,400.00
101	Хандив тусламж /дотоод/	376,232,300.00	435,278,400.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	20,410,930.00	22,715,700.00
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,410,930.00	22,715,700.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,410,930.00	22,715,700.00
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	332,325,268.90	438,376,991.43
148	УРСГАЛ ЗАРДАЛ	332,325,268.90	438,376,991.43
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	329,193,568.90	426,745,091.43
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	222,446,059.70	291,159,079.73
151	Үндсэн цалин	175,632,449.64	212,283,468.58
152	Нэмэгдэл	36,509,648.56	68,523,894.55
154	Үр дүнгийн урамшуулал	10,303,961.50	10,351,716.60
157	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	28,237,009.20	36,008,131.70

158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	18,920,779.06	24,899,734.97
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,499,269.72	2,997,342.27
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,983,959.74	2,314,273.62
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	434,851.54	524,473.93
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,398,149.14	5,272,306.91
164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	19,910,930.00	22,215,700.00
165	Гэрэл цахилгааны зардал	3,382,898.00	4,478,972.57
166	Түлш, халаалтын зардал	14,638,032.00	16,224,721.18
167	Цэвэр, бохир усны зардал	1,890,000.00	1,512,006.25
181	Нормативт зардал	46,929,300.00	56,180,530.00
183	Хоол, хүнс	46,929,300.00	56,180,530.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
189	Урсгал засвар	500,000.00	500,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	737,400.00
200	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	737,400.00
208	Бараа үйлчилгээний бусад зардал	11,170,270.00	19,944,250.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	9,865,220.00	17,260,050.00
210	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	1,305,050.00	2,684,200.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,131,700.00	11,631,900.00
225	Бусад урсгал шилжүүлэг	3,131,700.00	11,631,900.00
233	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	3,131,700.00	11,631,900.00
250	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	64,317,961.10	19,617,108.57
251	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
279	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
303	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	64,317,961.10	19,617,108.57
304	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	64,317,961.10
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	64,317,961.10	83,935,069.67

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	газрын оруулсан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
0	ДАНС	511	51300	51210+51220	
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	71,758,549.95	92,646,700.27	196,851,106.26	361,256,356.48
10	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	71,758,549.95	92,646,700.27	196,851,106.26	361,256,356.48
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	71,758,549.95	92,646,700.27	196,851,106.26	361,256,356.48
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0	0	42,980,480.40	42,980,480.40
18	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	71,758,549.95	92,646,700.27	239,831,586.66	404,236,836.88

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний	-	64,317,961.10	(64,317,961.10)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН	522,312,000.00	438,376,991.43	83,935,008.57	83.93
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	522,312,000.00	438,376,991.43	83,935,008.57	83.93
4	Бараа, үйлчилгээний зардал	510,680,100.00	426,745,091.43	83,935,008.57	83.56
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	361,410,200.00	291,159,079.73	70,251,120.27	80.56
6	Үндсэн цалин	240,204,300.00	212,283,468.58	27,920,831.42	88.38
7	Нэмэгдэл	107,134,800.00	68,523,894.55	38,610,905.45	63.96
9	Урамшуулал	14,071,100.00	10,351,716.60	3,719,383.40	73.57
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	45,176,400.00	36,008,131.70	9,168,268.30	79.71
12	Тэтгэврийн даатгал	30,719,900.00	24,899,734.97	5,820,165.03	81.05
13	Тэтгэмжийн даатгал	3,614,100.00	2,997,342.27	616,757.73	82.93
14	ҮОМШӨ ний даатгал	2,891,300.00	2,314,273.62	577,026.38	80.04
15	Ажилгүйдлийн даатгал	722,900.00	524,473.93	198,426.07	72.55
16	Эрүүл мэндийн даатгал	7,228,200.00	5,272,306.91	1,955,893.09	72.94
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол	22,215,700.00	22,215,700.00	-	100.00
18	Гэрэл цахилгаан	4,813,200.00	4,478,972.57	334,227.43	93.06
19	Түлш, халаалт	15,134,900.00	16,224,721.18	(1,089,821.18)	107.20
20	Цэвэр, бохир ус	2,267,600.00	1,512,006.25	755,593.75	66.68
30	Нормативт зардал	58,539,500.00	56,180,530.00	2,358,970.00	95.97
32	Хоол, хүнс	58,539,500.00	56,180,530.00	2,358,970.00	95.97
34	Эд хогшил худалдан авах	500,000.00	500,000.00	-	100.00
38	Урсгал засвар	500,000.00	500,000.00	-	100.00
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,	894,800.00	737,400.00	157,400.00	82.41
49	Мэдээллийн технологийн зардал	894,800.00	737,400.00	157,400.00	82.41
53	Бараа үйлчилгээний бусад зардал	21,943,500.00	19,944,250.00	1,999,250.00	90.89
54	Бараа үйлчилгээний бусад зардал	19,259,200.00	17,260,050.00	1,999,150.00	89.62
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,684,300.00	2,684,200.00	100.00	100.00
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,631,900.00	11,631,900.00	-	100.00
70	Бусад урсгал шилжүүлэг	11,631,900.00	11,631,900.00	-	100.00
78	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	11,631,900.00	11,631,900.00	-	100.00
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	522,312,000.00	457,994,100.00	64,317,900.00	87.69
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	435,278,400.00	435,278,400.00	-	100.00
99	Улсын төсвөөс санхүүжих	435,278,400.00	435,278,400.00	-	100.00

103	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22,715,700.00	22,715,700.00	-	100.00
104	Орон нутгийн төсвөөс	22,715,700.00	22,715,700.00	-	100.00
110	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ	64,317,900.00	-	64,317,900.00	-
113	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	64,317,900.00	-	64,317,900.00	-
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний	-	64,317,961.10	(64,317,961.10)	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн	-	83,935,069.67	(83,935,069.67)	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	20.00	20.00	-	100.00
134	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
135	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00	-	100.00
136	Үйлчлэх ажилтан	7.00	7.00	-	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Жаргалант сумын Дэжид цэцэрлэг нь сургуулийн өмнөх насны хүүхдийг бие бялдар оюун ухаан нийгэмшихүй хөгжлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Жаргалант сумын Дэжид цэцэрлэг нь 2023 оныг "Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтыг дэмжих" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 7 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 93 хувиар биелүүлж ажилласан байна.

Тус цэцэрлэг нь 20 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай

Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

2023 оны 11 сард аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг шалгалтаар 89,4 хувьтай үнэлэгдсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Жаргалант сумын Дэжид цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Жаргалант сумын Дэжид цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 37,900.3 мянган төгрөгөөр буюу 11,9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	64,317.9	83,935.0	19,617.1
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	52,558.1	54,696.4	2,138.3
Үндсэн хөрөнгө	244,488.2	266,004.4	37,900.3
Нийт хөрөнгө	361,364.3	404,635.8	43,271.4
Өр төлбөр	108,0	399.0	399.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	361,256.3	404,236.8	42,980.5
Дахин үнэлгээний зөрүү			
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	361,364.3	404,635.8	43,271.4

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны жилийн эцэст мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 19,617.1 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авалтын үнийн өсөлтөөс, мөн өмнөх оны үлдэгдэл санхүүжүүлэлт орж ирсэн зэргээс шалтгаалсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 2,138.3 мянган төгрөгөөр өссөн нь Дэлхийн зөн ОУБ-с хандивласан 500.0 мянган төгрөгийн угаалтуур, мөн хүнсний материал нөөцөлсөн нь холбоотой байна.

Үндсэн хөрөнгө данс нь 37,900.3 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар 1,012.0 мянган төгрөгийн компьютер, орон нутгийн хөрөнгөөр 30,949.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 5,939.3 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсантай холбоотой.

Өглөг данс 399.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь нүүрс халаалтын мөнгө дутуу шилжүүлсэнтэй холбоотой тус тус өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 435,278.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 22,715.7 мянган төгрөг, нийт зардлыг 457,994.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 457,994.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 435,278.4 мянган төгрөгийг, орон нутгийн төсвөөс 22,715.7 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 438,377.0 мянган төгрөг буюу 95,8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 19,617.0 мянган төгрөгөөр, үүнээс цалингийн зардал 5,933.2 мянган төгрөгөөр, хоол хүнс 2,358.9 мянган төгрөгөөр, бусад зардал 2,156.6 мянган төгрөгөөр, бүх төрлийн даатгалын зардлаас 9,168.2 мянган төгрөгөөр, тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	71801-Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,342.1	1,340.0	2.1	99,8%
2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	57,014.9	54,655.9	2,359.0	99,8%
3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	3,053.3	3,053.3		100%
4	81823-Багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	1,482.1	846.0	636.1	57,1%
5	81834 Боловсролын стандарт	302,320.2	245,106.1	57,214.0	81,1%
6	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	129,493.2	108,629.7	20,863.5	83,9%
7	81832 Нүүдлийн бүлэг	4,890.5	2,030.2	2,860.3	41,5%
8	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	22,715.7	22,715.7		100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Жаргалант сумын Дэжид цэцэрлэг нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71801-81605	2023-12-31	Эрүүл мэндийг дэмжих	99,8%	1,342.1	1,340.0
2	71801-81807	2023-12-31	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	95,9%	57,014.9	54,655.9
3	71801-81816	2023-12-31	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	100%	3,053.3	3,053.3
4	71801-81823	2023-12-31	Багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	57,1%	1,482.1	846.0
5	71801-81832	2023-12-31	Нүүдлийн бүлэг	41,5%	4,890.5	2,030.2
6	71801-81834	2023-12-31	Боловсролын стандарт	81,1%	302,320.2	245,106.1
7	71801-81835	2023-12-31	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	83,9%	129,493.2	108,629.7
8	71801-80111	2023-12-31	Тогтмол зардал	100%	22,715.7	22,715.7

Цэцэрлэгийн хүүхдийн хоол арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь сургуулийн хүүхдийн улирлын амралттай холбоотойгоор хүүхдийн ирц багасдагтай холбоотойгоор хэмнэгдсэн. Нүүдлийн бүлэг үйлчилгээ арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь орон тоо хэмнэсэн, хүүхдийн ирцтэй холбоотойгоор хэмнэгдсэн. Нүүдлийн бүлэг арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь хүүхдийн ирц дутуу мөн орон тоо хэмнэсэнтэй холбоотой байна. Сургалтын хэвийн үйл ажиллагаа арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь үр дүнгийн урамшууллыг олгоогүй мөн ур чадварын нэмэгдэл олгоогүйгээс шалтгаалсан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Боловсролын газраас тендерт шалгаруулсан газруудаас шууд худалдан авалт хийсэн. Үүнд: Хүнсний материал 56,180.5 мянган төгрөг, аж ахуйн материал 1,493.5 мянган төгрөг, эм боох материал 165.0 мянган төгрөг, бичиг хэргийн материал 2,472.2 мянган төгрөг, түлш 21,201.0 мянган төгрөг, хангамжийн материал 3,584.9 мянган төгрөг нийт 85,597.1 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Жаргалант сумын Дэжид цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах ажиллагчидтай холбоотой авлагыг барагдуулах, дансны үлдэгдлийг улирал, жилийн санхүүгийн эцэст баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн аудитор С.Дашдондог, аудитор Б.Мягмар нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын Дэжид цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 330,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 6,600.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5,280.0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хэмнэж ажилласны үр дүнд ажиллагсдад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Жаргалант сумын Дэжид цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэн ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорх хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 70,251.1 мянган төгрөгөөр
- Нормативт зардлыг 2,539.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Жаргалант сумын Дэжид цэцэрлэг нь 2023 онд шилэн дансанд 159 мэдээлэл оруулахаас 153 мэдээллийг хугацаанд нь мэдээлж 6 мэдээлэл хоцроож байршуулсан байна. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3-д “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхдээ нэг ч мэдээлэл хоцруулахгүй байхыг анхааруулж, зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гаргаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүнба өмнөх аудитаар өгсөн алдаа зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Жаргалант сумын Дэжид цэцэрлэг нь 2023 оны эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 2 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь

Акт				
Албан шаардлага				
Зөвлөмж	1		1	100
Нийт дүн	1		1	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Жаргалант сумын Дэжид цэцэрлэгт дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,236.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 1,236.1 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн. Үүнд:

5.3 Зөвлөмж

1. Зардлын данстай холбоотой

Илрүүлэлт:

Харилцагч байгууллагаас ирсэн хүнсний материалыг анхан шатны баримтгүй шууд зардалд бичсэн 1,236.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”, “Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж

Анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Харилцагч байгууллагаас ирсэн хүнсний материалыг анхан шатны баримтгүй шууд зардалд бичсэн	1	1,236.1					1	1,236.1				
Дүн	1	1,236.1					1	1,236.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган

төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
2023 онд шилэн дансанд 159 мэдээлэл оруулахаас 153 мэдээллийг хугацаанд нь мэдээлж 6 мэдээлэл хоцроож байршуулсан байна	1						1	
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn